

БАТЛАВ.  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Г.АНХБОЛД

2025 оны 06 дугаар сарын 12-ний өдөр



БАТЛАВ.  
"ЮНАЙТЭД АРТС ГРУПП"  
ХХК –НИЙ ЗАХИРАЛ  
Д. Тухмагбаяр Д.ЭНХТАЙВАН

2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр



### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 06 дугаар сарын 9-ний өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний Хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1; 343 дугаар зүйлийн 343.1 болон бусад холбогдох заалтуудыг үндэслэн нэг талаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (РД:5098785) /цаашид "Захиалагч" гэх/-ийг төлөөлж Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Д.Азбаяр, нөгөө талаас 6107206 тоот регистрийн дугаартай "Юнайтэд артс групп" ХХК /цаашид "Гүйцэтгэгч" гэх/-ийг төлөөлж менежер Г.Сайнжаргал нар /цаашид "Талууд" гэх/ харилцан тохиролцож, энэхүү "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээний зорилго: Оюутан залуусын эрүүл мэндийг дэмжих, хорт зуршлын хэрэглээг бууруулах зорилгоор "Open Mic" арга хэмжээг хамтран зохион байгуулах болон ажлын хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Талууд бие биеийнхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.
- 1.3 Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 1.4 Гүйцэтгэх ажлын хугацаа нь 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдөр эхэлж, 2025 оны 06 дугаар сарын 30 -ны өдөр дуусгавар болно.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1 Захиалагч тал төлбөрийг дансаар төлнө. Гэрээний нийт үнэ 8,100,000 (найман сая нэг зуун мянга) төгрөг төлөхөөр харилцан тохиролцов.
- 2.2 Захиалагч гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт төлбөрийг 100 хувь болох 8,100,000 (найман сая нэг зуун мянга) төгрөгийг гүйцэтгэгчийн Голомт банкны 3105135742 (IBAN: MN120015003105135742) тоот дансанд шилжүүлнэ.

### ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

#### 3.1 Захиалагчийн эдлэх эрх

- 3.1.1. Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг болон даалгасан ажлыг цаг алдалгүй гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.1.2. Арга хэмжээний үеэр үзүүлсэн бүтээлүүдэд хяналт тавих, нийтийн ёс зүй, олон нийтэд нийцтэй байдлыг шаардах эрхтэй.

- 3.1.3. Арга хэмжээний нэр, зорилго зөрөх, чиглэлээс хазайсан тохиолдолд зохион байгуулалтад хяналт тавих, шаардлага тавих эрхтэй.
- 3.1.4. Бүрэн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авах хүртлээ гэрээний үлдэгдэл төлбөрийг шилжүүлэхгүй байх эрхтэй.
- 3.1.5. Арга хэмжээний үеэр авсан зураг, бичлэг, контентыг ашиглах эрхтэй.

### **3.2 Захиалагчийн хүлээх үүрэг**

- 3.2.1. Энэхүү Гэрээнд заасан төлбөрийг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж хасахгүйгээр гэрээгээр тохирсны дагуу олгох,
- 3.2.2. Гэрээний төлбөрийг хугацаанд нь шилжүүлэх
- 3.2.3. Гүйцэтгэгчид энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нь шаардагдах бүхий л мэдээ, мэдээлэл, зааварчилгааг өгөх.

## **ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **4.1 Гүйцэтгэгчийн эдлэх эрх**

- 4.1.1. Захиалагчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,
- 4.1.2. Шаардлагатай материалыг урьдчилан гаргаж өгөхийг шаардах,
- 4.1.3. Гүйцэтгэгч нь гэрээгээр тохиролцсон хөлс авах зэрэг байна.

### **4.2 Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг**

- 4.2.1 Гүйцэтгэгч нь 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр “Тамхины үнэнг илчилье – Тамхигүй хойч үеийн төлөө” уриан дор оюутан, залуучуудад чиглэсэн нээлттэй илэрхийллийн арга хэмжээг (Open Mic event) Улаанбаатар Цэцэрлэгт хүрээлэнгийн Рио Тинто задгай театрт зохион байгуулна.
- 4.2.2 Гүйцэтгэгч өөрийнхөө үйл ажиллагааны явцад олсон мэдээллийг үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхлын эсрэг ашиглахгүй бөгөөд аливаа нууц мэдээллийг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй, задруулахгүй байх;
- 4.2.3 Гүйцэтгэгч ажлыг чанарын өндөр түвшинд, стандартын дагуу, гэрээгээр тохирсон хугацаанд гүйцэтгэх;
- 4.2.4 Гүйцэтгэгч нь арга хэмжээний уран бүтээлчид болон оролцогчдыг сонгон шалгаруулах, үзүүлбэрийн зохион байгуулалт, тайзны менежмент, дуу хөгжим, микрофон, тоног төхөөрөмжөөр хангах, мөн байгууллагынхаа социал сувгаар арга хэмжээг сурталчлах;
- 4.2.5 Гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын үйл явцад илэрсэн зөрчил, чанарын доголдлыг өөрийн хөрөнгөөр арилгах, нөхөн гүйцэтгэх;
- 4.2.6 Гүйцэтгэгч тал нь видео контентуудыг олон нийтэд хүргэхэд холбогдох бүхий л арга хэмжээг авч ажиллана.

## **ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 5.1 Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх үр дагавар, хариуцлагыг үүргээ биелүүлээгүй тал хариуцна.

- 5.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр тохирсон хугацаандаа гэрээний үүргээ биелүүлээгүй, эсхүл гэрээний үүргээ ямар нэгэн байдлаар зөрчсөн тохиолдолд захиалагч талд гэрээний үнийн дүнгийн 10 хувийн торгууль төлнө.
- 5.3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаандаа бүрэн биелүүлээгүйгээс захиалагчид учирсан хохирлыг гүйцэтгэгч тал хариуцан барагдуулна.
- 5.4. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын улмаас захиалагч талын эрх ашиг, нэр төрд хохирол учирсан тохиолдолд учирсан хохирлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

### ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
- 6.2. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

### ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 7.1 Энэ гэрээний эхийг 2 хувь үйлдэж, Гүйцэтгэгч 1 хувь, Захиалагч 1 хувийг хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй байна.
- 7.2 Энэхүү гэрээг Талууд харилцан тохиролцсоноор бүх төлбөр тооцоог барагдуулж дуусгавар болгоно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч:

Д.Азбаяр

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Утас: 11458298

Хаяг:

УБ хот, Баянзүрх дүүрэг,  
34-р хороо, Шархад 50 гудамж

Гүйцэтгэгч:

Г.Сайнжаргал

"Юнайтэд артс групп" ХХК-ний менежер

Утас: 88073118

Хаяг:

УБ хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо,  
4-190тоот



..... тоот гэрээний дугаар

ОЮУТАН ЗАЛУУСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, ХОРТ ЗУРШЛЫН ХЭРЭГЛЭЭГ  
БУУРУУЛАХ ЗОРИЛГООР "OPEN MIC" АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНИЙН ЗАДАРГАА

№	Үйл ажиллагаа	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (₮)	Нийт үнэ (₮)
1	Dynacord 12.3 -дуу дүрсний төхөөрөмж (Ашиглалтын зардал)	2	1,000,000	2,000,000
2	Presonus mixer -дуу дүрсний тоног төхөөрөмж	1	1,100,000	1,100,000
3	Microphone -том зөөврийн өсгөгч	2	700,000	1,400,000
4	Black magic 6k pro video camera, 50 lens-багц	1	1,300,000	1,300,000
5	Холбогч кабель болон бусад дагалдах хэрэгсэл(тог татах)	-	300,000	300,000
6	Туг, суурь, гэрэлтүүлэг (НЭМҮТ, АМСА, ДЭМБ, СЭМҮТ)	4	500,000	2,000,000
Нийт дүн				8,100,000

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч:

*Д.Азбаяр*

Д.Азбаяр

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Утас: 11458298

Хаяг:

УБ хот, Баянзүрх дүүрэг,  
34-р хороо, Шархад 50 гудамж

Гүйцэтгэгч:

*Г.Сайнжаргал*

Г.Сайнжаргал

"Юнайтэд артс групп" ХХК-ний менежер

Утас: 88073118

Хаяг:

УБ хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо,  
4-190тоот

УЛААНБААТАР ХОТ  
5096785 9020110159 ЭТА1121

УЛААНБААТАР ХОТ  
1116228086 6107206

Хууль зүйн сайдын 2016. оны  
... Л/204... дугаар тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000127963



2016.09.15

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011625106

/ Хувийн хэргийн дугаар /

6107206

/ Регистрийн дугаар /

Юнайтэд артс групп

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсээн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2016.09.14

/ Шийдвэрийн нэр /

/ Дугаар /

/ он, сар, өдөр /

6810

/ код /

Үл хөдлөх хөрөнгийн зуучлал

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4774

9329

4610

7310

9000

Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ

Урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулах

Гадаад худалдаа

Зар сурталчилгаа хийх

Дуу дүрс бичлэг хийх

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

20,00

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянзүрх, 7-р хороо, 15 хороолол, 37а, 26 тоот, Утас1: 88073118, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэл, статистикийн  
ерөнхий газрын Хуулийн  
этгээдийн бүртгэлийн газар  
/ бүртгэсэн байгууллагын нэр /

1116 115810

УХАД565

5296722

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлийн агуулга	Бүртгэсэн Огноо
1	Дэвсгэмбүү овогтой Энхтайванд Захирал-р томилогча бүртгэв	2016.09.15



4 0 0 0 1 2 7 9 6 3 4

## ДЭЛХИЙН ТАМХИГҮЙ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛСАН “ТАМХИНЫ ҮНЭНИЙГ ИЛЧИЛБЕ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

### Хэрэгжүүлэгч байгууллага:

- Эрүүл мэндийн яам
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- Азийн анагаахын оюутны холбоо

**Байршил:** Улаанбаатар цэцэрлэгт хүрээлэн (Рио Тинто) -ийн Задгай театр

**Хугацаа:** 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

### Зорилго:

Хүүхэд залуучуудад электрон тамхи ба тамхин бүтээгдэхүүний хэрэглээнээс сэргийлэх, тамхины хор хөнөөл, тамхины хэрэглээ ба хамаарлын оношилгоо, эмчилгээ, тамхинаас гарах зөвлөгөө өгөх аргачлалын чиглэлээр сургалт зохион байгуулах, олон нийтэд тамхины хор хөнөөлийг таниулах зорилгоор үйл ажиллагаа зохион байгуулах

### Зорилт:

1. Олон нийтэд тамхин бүтээгдэхүүний хор хөнөөлийн талаар мэдлэг, боловсрол олгох
2. Тамхигүй ажлын байрыг нэмэгдүүлэх
3. Тамхинаас гарах, тамхиа хаях хүмүүсийг дэмжих зөвлөгөө мэдээлэл, эмчилгээний мэдлэг ойлголт өгөх

### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Олон нийтэд тамхи, электрон тамхины хор хөнөөлийг таниулах контент, постер хийж, түгээх
  - А. Тамхи ба түүний хор хөнөөл
  - В. Тамхинаас хэрхэн татгалзах зөвлөгөө
2. Рио Тинто цэцэрлэгт хүрээлэнд олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах
  - А. Тамхи, электрон тамхины хор хөнөөлийн тухай “АХА” тэмцээн зохион байгуулах
  - В. Тамхинаас гарах арга зүйн зөвлөгөө мэргэжлийн эмч, сэтгэл зүйч нар өгөх
  - С. Хүүхэд, өсвөр үеийнхэнд тамхи бол стресс тайлах арга биш сургалт хийх

3. Тамхигүй ажлын байр ажлыг бий болгох уриалга дэвшүүлж, албан байгууллагууд уриалгыг орон нутаг, нийслэлийн харьяа байгууллагуудад түгээх
4. Тамхинаас гаргах эм, наалт зэрэг эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эмийн эмчилгээг олон нийтэд сурталчлах
5. Тамхинаас гаргах эмчилгээний талаар эрүүл мэндийн ажилтнуудад сургалтыг цахимаар болон танхимаар хийх

#### Хамтран ажиллах байгууллагууд :

- Нийслэлийн эрүүл мэндийн газар
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг
- Нийслэлийн боловсролын ерөнхий газар
- Төрийн бус байгууллагууд

#### Санхүүжүүлэгч байгууллага: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

**ДЭЛХИЙН ТАМХИГУЙ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРӨӨХ**  
**"ТАМХИНЫ ҮНЭНИЙГ ИЛЧИЛЬЕ" АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

5-Р САРЫН 30-НД 16:30 - 18:30  
 УЛААНБААТАР ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, РИО-ТИНТО-ИЙН ЗАДГАЙ ТҮЭТР

ХУГАЦАА	ҮЙД АЖИЛЛАГАА
16:30-17:00	Чөлөөт арга хэмжээ: Open mic Mongolia
17:00-17:10	Нээлтийн үйл ажиллагаа
17:10-17:20	Бодит туршлага: Тамхинаас гарсан миний түүх
17:20-17:25	Урлагийн үзүүлбэр: Дуучин О.З
17:25-17:40	Залуучуудын хөгжил ба эрүүл амьдрал: Панел хэлэлцүүлэг
17:40-17:50	Хамтдаа тархиа мөн биеийн буачингаа ажиллуулцгаа
17:50-17:55	Урлагийн үзүүлбэр: Дуучин Zayashii
17:55-18:05	Хаалт/Уриа хэлж, амлалт өгөх
18:05-18:35	Чөлөөт арга хэмжээ: Open mic Mongolia

Үнэн төрхийг илчилъе! #TobaccoExposed

## **Дэлхийн тамхигүй өдрийг тэмдэглэн өнгөрөөх “ТАМХИНЫ ҮНЭНГ ИЛЧИЛЬЕ” арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа**

1987 онд ДЭМБ-ын гишүүн орнууд тамхинаас үүдэлтэй, урьдчилан сэргийлэх боломжтой нас барагчдын тухай асуудалд анхаарах хандуулах үүднээс анхны “World No-Smoking Day” санаачилгыг гаргажээ. 1988 оны 4-р сарын 7-ны ДЭМБ-ын Ассамблейн WNA40.38 тогтоолоор 1988 оны 4-р сарын 7-нд анх нэг өдрийн тэмдэглэлт өдрийг “Дэлхийн Тамхигүй Өдөр” болгожээ. Иймээс Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) 1988 оноос эхлэн 5 дугаар сарын 31-нийг жил бүр “Дэлхийн Тамхигүй Өдөр” болгон тэмдэглэж байна.

Энэ жилийн Дэлхийн Тамхигүй Өдрийн уламжлалт арга хэмжээ нь “Худалд хууртаж болохгүй! Тамхины үнэнг илчилъе!” уриатайгаар зохион байгуулагдаж байна. Тамхи ба никотин агуулсан бусад бүтээгдэхүүн буюу электрон тамхины үйлдвэрлэл, борлуулалт нь өнөөгийн нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудын нэг болсон бөгөөд ялангуяа залуу үеийн сонирхлыг татах зорилгоор бүтээгдэхүүнүүдийн бодит шинж чанарыг нууцлах, сонирхол татахуйц болгох арга хэмжээнүүд түгээмэл хэрэглэгддэг байна. Эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлд амт, үнэрийг сайжруулах, гадаад төрхийг өөрчлөх зорилгоор нэмэлт бодисуудыг ашигладаг бөгөөд үүнээс үүдэн тамхины бодит чанарыг далдлах, амтыг сайжруулах замаар хүүхэд залуучуудад зориулж тамхины сэтгэл татам байдлыг нэмэгдүүлэх зэрэг үр дүнд хүрдэг байна. Эдгээр арга замууд нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж хүлээн зөвшөөрөгдөж байгаа бөгөөд үүнийг илчлэх, хэрэгжүүлэхгүй байхын тулд олон нийтийн зөв мэдээлэл хүргэх, хууль эрх зүйн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм.

Иймд Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл Монгол Хүн үндэсний хөдөлгөөн, Боловсролын ерөнхий газар, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, AMSA Mongolia-тай хамтран хүүхэд залуучуудад тамхи ба электрон тамхины хор хөнөөлийг таниулах, тамхинаас гаргах эмчилгээ, зөвлөгөө сургалт зохион байгуулах, электрон тамхины хэрэглээний бодит аюулын тухай олон нийтэд зөв мэдээлэл хүргэж, электрон тамхи ба тамхин бүтээгдэхүүний хэрэглээнээс сэргийлэх зорилгоор олон нийтэд уриалсан арга хэмжээ зохион байгуулав.

Арга хэмжээний нээлтийг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Сокорро Эскаланте болон ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат нар хийв.




### Сургагч багш Ганболд: Тамхинаас гарсан миний түүх

Анх өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндийн төлөө ухамсарлан, бага багаар тамхины хэрэглээгээ багасгаж, эцэст нь бүрэн гарч чадсан байдаг. Ихэнх нь дэмжлэг үзүүлсэн гэр бүл, найз нөхдийн туслалцаа, мөн эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөний ачаар амжилтад хүрсэн гэдгээ онцоллоо.



Хөтөлбөрийн дагуу Дуучин O.Z, Дуучин Zayashii нар дуулсан бөгөөд Open Mic Mongolia-аас зохион байгуулсан чөлөөт арга хэмжээнд хүүхэд залуучууд идэвхитэй оролцлоо.





Залуучуудын хөгжил ба эрсдэл сэдэвт панел хэлэлцүүлгийг “Master Brain Mongolia” ХХК-ийн сэтгэл засалч эмч, донтох эмгэг судлаач Ж.Гантупга удирдан чиглүүлж, электрон тамхины хор хөнөөл, залуучуудыг тамхины хэрэглээнээс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлэв.

Дараа нь Монгол дахь Азийн Анагаахын Оюутнуудын Холбооны гишүүд “Хамтдаа тархиа мөн биеийн булчингаа ажиллуулцгаая” сэдэвт флэш-моб зохион байгуулж, олон нийтийг хамруулав.

Арга хэмжээний үеэр хүүхэд залуучуудад зориулсан “Тамхигүй хойч үеийн төлөө” гарын үсэг зурах самбар, “Би тамхи татахгүй” селфи хийх толь зэрэг сонирхолтой булангуудыг ажиллуулав.



## Монгол улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг:

ЭМЯ болон бусад залуучуудын төлөөлөлд талархлаа илэрхийлье. Та бидний өөрсдийн оролцоо манлайлал чухал гэдгийг ойлгож авсан байх гэж бодож байна. Нэг удаагийн арга хэмжээ биш цаашид жил болгон зохионо гэдэгт итгэж байна. Тэрбээр иргэдийг эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэн, тамхинаас ангид байхыг уриалав. Тэрээр “Тамхигүй ирээдүйн төлөө өнөөдөр шийдвэрээ гаргацгаая” хэмээн онцолж, төр засгийн зүгээс иргэдийн тамхинаас гарах хүсэл, оролдлогыг бүх талаар дэмжин ажиллах болно гэдгээ илэрхийлэв. Мөн өсвөр үе, залуучуудыг энэ хорт зуршлаас хамгаалахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлнэ хэмээн амлалт өглөө.

Бид, Монгол залуус, **ӨӨРСДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХ, ИРЭЭДҮЙНХЭЭ ТӨЛӨӨ** дуу хоолойгоо нэгтгэж байна.

Энэ жилийн Дэлхийн тамхигүй өдөр бид тамхи болон тамхины далд аюул, үнэнийг илчлэх уриалга дэвшүүлж байна.

Удирдагчид, бодлого боловсруулагчид, гэр бүл, хамт олон, нийгмийн бүхий л гишүүдийг дараах уриалгад нэгдэхийг Бид хүсэж байна:

- Ашгийн төлөө хүүхэд, залуусыг ашиглан төөрөгдүүлж буй явдлыг таслан зогсоо.
- Тамхи болон электрон тамхины ханган нийлүүлэлт, худалдаа, сурталчилгаа, идэвхжүүлэлтийн бүх хэлбэрт бүрэн хяналт тогтоосон, хатуу хууль, зохицуулалтыг баталж, чанд хэрэгжүүлье.
- Сурууль, олон нийтийн тээвэр, цахим орчныг тамхи, электрон тамхицаж ангид орчин болгоё.
- Тамхи болон электрон тамхины бизнесийг бидний амьдрал, гэр бүл, нийгмээс ангид байлгая. Бид тамхигүй хойч үеийг бүтээнэ.





**Өөрсдийн эрүүл мэнд, эрх,  
ИРЭЭДҮЙГЭЭ ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ**  
тамхины үнэнийг илчилъе.

2025 оны 5 дугаар сарын 30  
Монгол Улс, Улаанбаатар хот

Үнэн төрхийг илчилъе! #TobaccoExposed

**Олон нийтэд тамхи, электрон тамхины хор хөнөөлийг таниулах, тамхинаас хэрхэн татгалзах зөвлөгөө контент, social media постер**

ЭМЯ, СЭМҮТ, НЭМҮТ нар 5-р сарын 31-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд олон нийтийн сүлжээгээр “Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилье” уриан дор залуус, эцэг эхчүүд, боловсролын салбарынхан болон олон нийтийг тамхи, никотины бүтээгдэхүүнээс хамгаалах хатуу бодлого шаардсаар байхыг уриалж байгаа ба үүний тулд тамхины үйлдвэрлэлийн хорт аргыг илчилж, ташаа мэдээллийг няцаан, Монгол Улсад яаралтай бодлогын шинэчлэл хийхийг дэмжих олон нийтийн дэмжлэгийг бий болгоход чиглэн явуулж байна.

Date	Campaign material	CAPTION
<p>5-р сарын 31</p>	 <p>Постер 1</p>	<p>Гаднаасаа гэмгүй мэт харагдавч ямар ч сав баглаа боодолтой байсан аюултай. Загвар нь өөрчлөгдөж болох ч аюул нь хэвээр.</p> <p>Тамхи, никотин агуулсан бүтээгдэхүүн, түүний дотор электрон тамхи нь эрүүл мэндэд хортой, хүчтэй донтуулдаг. Тамхины үйлдвэрлэл эрхлэгчид үүнийг мэддэг хэрнээ залуусыг бай болгосоор байна.</p> <p>Хуурамч төрхийг эвдье. Тэдний арга мэхийг илчилье.</p> <p>Энэ жилийн  Дэлхийн тамхигүй өдрөөр тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилье.</p>
<p>5-р сарын 31</p>	  <p>Manifesto 1_MON.png</p> <p>Manifesto 2_EN.png</p> <p>Тунхаглал</p>	<p>Тамхигүй хойч үеийн төлөөх Монгол залуусын тунхаглалд нэгдэцгээе!</p> <p>Эрүүл, тамхигүй ирээдүйн төлөөх Монгол залуусын тунхаглалыг дэмжиж, энэ мэдээллийг өөрийн цахим сүлжээгээр түгээж, бусдыг уриалаарай.</p>

6-р сарын 2



Зураг 2

Бохь, манго, эсвэл чихэр шиг амт — эдгээр нь амт биш, урхи юм. Эдгээр нь таныг электрон тамхинд донтуулах зорилготой бөгөөд эрүүл мэндэд хортой!

Амттан мэт санагдах ч амь насанд аюултай химийн хорт бодисыг нуудаг бөгөөд насан туршийн донтолт, эрүүл мэндэд хор уршгийг дагуулдаг.

Хуурмаг дүр төрхөд бүү хуурт. Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилъе.

6-р сарын 3



Богино хэмжээний бичлэг

Электрон тамхи нь эрүүл мэндэд хортой. Тамхинаас гарахад тусалдаг хэрэгсэл биш юм.

Тэдгээрээс гарах утаа, ууршилт нь хэрэглэгч болон хэрэглэгчийн ойр байгаа хүмүүст ч хортой.

Одоо шийдвэртэй хандаж, тамхигүй байх цаг болсон.

6-р сарын 4



Зураг 4

Амт нь донтолтод оруулах урхи юм.

Тамхи нь 20 гаруй төрлийн хорт хавдар үүсгэдэг бөгөөд хэрэглэгчдийнхээ тапаас илүү хувийн амь насыг авч оддог.

Үйлдвэрлэгчдэд хууртах хэрэггүй!

🚫 Худалд бүү итгэ. Тамхинаас татгалз.

6-р сарын 5



Тамхи, электрон тамхины компаниуд хөгийн үнэнийг нууж чадахгүй:

Тамхи хэрэглэдэг эсэхээс үл хамааран, бүх төрлийн тамхи, электрон тамхи нь донтуулах ба эрүүл мэндэд хортой.

Эдгээр хорт бүтээгдэхүүнийг гэр бүл, нийгэм, хүүхдүүдийнхээ амьдралаас хол байлгацгаая!

Энэ  Дэлхийн тамхигүй өдөр хамтдаа үнэнийг илчилье!



Зурагт ном

6-р сарын 6




Зураг 5

Амтанд бүү хуурт. Үнэнийг илчил!

Шиша нь химийн хорт бодисууд болон хорт хавдар үүсгэгчдийг агуулдаг бөгөөд дараах эрсдэлүүдийг нэмэгдүүлдэг:

- Уушги ба зүрхний өвчин
- Никотинд донтох
- Хамт хэрэглэдэг амны хошуунаас халдвар авах

Аюулгүй хэрэглээ гэж үгүй!

 Дэлхийн тамхигүй өдөр

6-р сарын 9



Зураг 6 - бичлэг

Тамхины үйлдвэрүүд бүтээгдэхүүн нь насанд хүрэгчдэд зориулсан гэж хэлдэг.

Тэгвэл яагаад тэд тоглоом шиг харагддаг вэ?

Чихрийн амт, гялгар өнгө, загварлаг дизайн гэх мэтийг ашиглан хүүхдүүдийг бай болгож байна.

Тамхины үнэнийг илчилъе!

6-р сарын  
10



Зураг 7

Филтер бол тамхийг аюулгүй мэт харагдуулах маркетингийн арга юм. Филтертэй байсан үгүй тамхи таны амь насанд аюултай.

Филтер нь хүмүүсийг тамхи татаж эхлэхэд амар болгож, больход хүндрэлтэй болгодог.

Эдгээр нь уушгины түргэн явцтай хорт хавдрын тохиолдлыг ч нэмэгдүүлж байна.

🚭 Дэлхийн Тамхигүй Өдөр

6-р сарын  
11

Subtitled video



Зураг 8

Тамхи, электрон тамхины компаниуд загварлаг дизайн, савлагаагаар хүүхэд, өсвөр үеийг онилсоор байна.

Одоо шийдэмгий зогсож, #Тамхигүй гэж хэлэх цаг!

6-р сарын  
12



Зураг 9

Бохь, манго, эсвэл чихэр шиг амт — эдгээр нь амт биш, урхи юм. Эдгээр нь таныг электрон тамхинд донтуулах зорилготой бөгөөд эрүүл мэндэд хортой!

Амттан мэт санагдах ч амь насанд аюултай химийн бодисыг нуудаг бөгөөд насан туршийн донтолт, эрүүл мэндэд хор уршгийг дагуулдаг.

Хуурмаг дүр төрхөд бүү хуурт. Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилъе.

6-р сарын  
13



Зурагт ном 2

Тамхины үйлдвэрүүд бүтээгдэхүүн нь насанд хүрэгчдэд зориулсан гэж хэлдэг.

Гэтэл хар даа:

- 🍷 Чихрийн амт
- 🌈 Гялалзсан тод өнгө
- 🐼 Хүүхэлдэйн дүрүүд
- 🌟 Дэгжин дизайн
- 🧸 Тоглоом мэт савлагаа

Энэ бол ичгүүргүй заль мэх! Тэд ашиг олохын тулд бидний хүүхдүүдийг онилж байна!

Энэ жилийн 🚫 Дэлхийн тамхигүй өдрөөр тамхины үйлдвэрүүдийн бохир нууцуудыг илчилцгээе!